

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР БАРИМТЛАХ СТРАТЕГИ
ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАН БАТЛААГҮЙ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭГ БОДИТ БАЙДАЛД НИЙЦҮҮЛЭН ХИЙДЭГГҮЙ
ЗЭРЭГ НЬ ХУУЛИЙН ТОДОРХОЙ ЗОХИЦУУЛАЛТЫГ ХАНГАХГҮЙ БАЙГААГ
ХАРУУЛЖ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХӨА-2024/19-21-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelqerb@audit.gov.mn

Ахлах аудитор: З.Даваадорж

Утас: 89100230 Цахим хаяг: Davaadorjz@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил

Утас: 99039344 Цахим хаяг: Munkh-Orgill@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

З.Даваадорж

Аудитор

Л.Мөнх-Оргил

Г.Ичинхорлоо

Б.Ариунтуяа

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2024 оны 11 дүгээр сар

Товчилсон үгийн жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1: Төрийн албаны хүний нөөцийн чиглэлээр баримтлах стратеги төлөвлөгөө боловсруулан батлаагүй, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг бодит байдалд нийцүүлэн хийдэггүй байна.

1.1 Хөвсгөл аймгийн хэмжээнд төрийн байгууллагын хүний нөөцийн чиглэлээр мөрдөх стратеги төлөвлөгөө батлаагүй, бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын бүх талын оролцоог хангаж ажиллаагүй байна.

1.2 Төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд нөөцийн хуваарилалтыг жигд хүртээмжтэй байдлаар хийх бодлого баримтлаагүй байна.

1.3 Эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийдэггүй, төрийн албан хаагчийг тогтвортой ажиллуулах нийгмийн баталгаагаар хангагдаагүй, төрийн албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлээгүй, улс төрийн нөлөөнөөс ангид байх зарчим хэрэгжихгүй байгаагаас үзэхэд хүний нөөцийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлж чадаагүй байна.

Бүлэг 2: Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байна уу?

2.1 Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийг дэмжин чадавхжуулсан байна.

2.2 Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай цахим системийг хөгжүүлж, шат дамжлагыг цөөлөн, иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах боломж бүрдсэн байна.

2.3 Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдалд үнэлгээ өгөхөд иргэд олон нийтийн оролцоо хангалтгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн жагсаалт

Тайлангийн хавсралтууд

Холбогдох байгууллагуудын санал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/45

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/62 дугаар тушаал, 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дахь заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хөвсгөл аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд тус тус хүргүүлсүгэй.
4. “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Т.Раднаабүд, Цагааннуур сумын Засаг дарга Б.Цэрэн-Очир нарт зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах аудитор (З.Даваадорж)-т үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-д даалгасугай.
7. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор З.Даваадорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 11
дүгээр сарын 20-ны өдрийн ...*А/45* дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”
гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Албан шаардлагын дугаар	Утга
1	94/A2270469/ХӨА-2024/19-21-ШТА-ГА	Зөрчил арилгуулах тухай
2	99/A2270469/ХӨА-2024/19-21-ШТА-ГА	Зөрчил арилгуулах тухай
3	100/ A2270469/ХӨА-2024/19-21-ШТА-ГА	Зөрчил арилгуулах тухай

ooOoo

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХӨА	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ШТА	Шууд тайлагнах аудит
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АЗД	Аймгийн Засаг дарга
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ТА	Төрийн алба
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАСЗ	Төрийн албаны салбар зөвлөл
ТАХ	Төрийн албан хаагч
ТЗУХ	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс
ХШҮХ	Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс
СХДАА	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Төрийн албыг чадахуйн зарчимд үндэслэн сонгох, томилох, үр дүнг үнэлэх, цомхон бүтцээр тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримталж, тухайн чиглэлээр ажиллах тогтолцоо, эрх зүйн орчин бүрэн бүрдсэн эсэх, төрийн албаны хүний нөөцийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт өгөх гэж аудитын зорилтыг тодорхойлов. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх;
- ❖ Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх;

Аудитын хязгаарлалт:

Аудитыг олон оныг хамруулж гүйцэтгэж байгаагаас шалтгаалан зарим онуудын баримт материал олдохгүй байх, тайлбар өгөх мэдлэгтэй албан хаагч, удирдлага байхгүй зэрэг хязгаарлалт үүссэн.

Аудитын хамарсан хүрээ:

Төрийн албаны тухай хуульд “Төрийн албан хаагч гэж төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ” гэж тодорхойлсны дагуу төрийн захиргааны, төрийн тусгай, улс төрийн, төрийн үйлчилгээний албан тушаалтнуудыг ажиллуулж байгаа төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын дунд, урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулж, батлуулж, мөрдөж байгаа аймаг, сумын ЗДТГ-ууд болон аймаг, сумын Засаг дарга нарын харьяа байгууллагууд, Хөвсгөл аймаг дахь яам, агентлагийн харьяа байгууллагуудын 2013 оноос 2023 он дуусах хүртэл хугацааны хүний нөөцийн үйл ажиллагааг хамруулан аудитыг гүйцэтгэсэн.

Аудит гүйцэтгэх хугацаа, багийн нөөцийн хүрэлцээг харгалзан Хөвсгөл аймгийн ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, сумдын ЗДТГ, Төрийн албаны салбар зөвлөл, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, Улаан-Уул, Рэнчинлхүмбэ, Цагааннуур сумын төрийн байгууллагууд, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газар, аймгийн эрүүл мэнд боловсролын салбарын байгууллагуудыг хамруулан нийт төрийн байгууллагын 40 хувьд түүвэрчилсэн хяналт хэрэгжүүлж, аудитын нэгдсэн судалгааг нийт төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудаас авсан.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь төрийн байгууллагууд, нутгийн захиргааны байгууллагуудын стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан, статистик мэдээ, шүүхийн шийдвэр, төрийн албаны зөвлөлийн маргаан шийдвэрлэлтийн тайлан мэдээлэл, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, түүнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, төрийн байгууллагуудын бүтэц, орон тоо, бүтцийн

өөрчлөлтийн мэдээлэл, хөдөлмөрийн дотоод журамд холбогдох бусад мэдээлэл, тайланд үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн тайланг боловсруулсан.

Аудитыг нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн бөгөөд төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүй нь аудитын бүх үе шатны туршид үргэлжлэх үйл ажиллагааг хамарсан.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор З.Даваадорж, аудитор Л.Мөнх-Оргил, Г.Ичинхорлоо, Б.Ариунтуяа нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ний өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль нь анх 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдаж, 1995 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн байна. Дээрх хуулийг 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр, 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн найруулж, хамгийн сүүлд 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хуульд нэмэлт оруулсан байна.

Төрийн албаны тухай хууль 1994 онд анхлан батлагдаж Монгол Улсын түүхэнд анх удаа төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх зарчимд суурилсан хуультай болж, түүнд нийцүүлэн гаргасан 20 гаруй эрх зүйн актаар төрийн албаны шинэ бодлогыг тодорхойлж, зохицуулан улмаар төрийн албаны өөрчлөлт шинэчлэлийн таатай орчныг бүрдүүлсэн байна. Ингэснээр манай улс гадаадын олон улс оронд үр дүнгээ өгсөн төрийн албаны “мерит” буюу “төрд тогтвортой үйлчлэх” тогтолцоог сонгосон гэж үзэж болно¹.

Төрийн албаны хүний нөөцийн бодлого, зохицуулалтыг Төрийн албаны тухай хууль, бодлогын шинэтгэлийн үе шатуудтай уялдуулан товчлон дүгнэвэл²:

1. Ардчилсан нийгмийн мөн чанарт нийцүүлэн төрийн байгууллын шинэ тогтолцоог бүрдүүлэх эхэн үе (1990-1995 он),
2. Төрийн мэргэшсэн албыг бүрдүүлж, төлөвшүүлэх үе (1996-2002 он),
3. Төрийн албаны үйл ажиллагааны үр дүн, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн үе (2003-2008 он),
4. Улс төрөөс ангид, мэдлэг чадварт суурилсан төрийн албыг бэхжүүлэх үе (2008 - эдүгээ хүртэл)

Улс төрөөс ангид, мэдлэг чадварт суурилсан төрийн албыг бэхжүүлэх төрийн албаны бодлого, тогтолцооны шинэтгэлийг УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-аар 2021

¹ Удирдлагын академи “Төрийн албаны хүний нөөцийн бодлого, зохицуулалтын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан 2021 он, 22-23 дугаар нүүр

² Удирдлагын академи “Төрийн албаны хүний нөөцийн бодлого, зохицуулалтын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ” судалгааны тайлан 2021 он, 32-33 дугаар

он хүртэл тодорхойлж байсан бол 2021 оноос “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогоор тодорхойлж байна.

УИХ-ын 2004 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-т төрийн албаны бодлогыг Иргэдэд ойр, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн, өөрчлөгдөж буй орчинд уян хатан зохицож чаддаг бөгөөд идэвхтэй, санаачилгатай манлайлагч менежер бүхий цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх гэж тодорхойлсон бол УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтоож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн албыг төлөвшүүлэн, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээтэй, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүхий хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоотой, авлигаас ангид төрийн албаны бодлогыг тодорхойлжээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-г тогтоолын 2 дугаар хавсралтаар баталж, бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн дараагийн үе шатны хүрэх үр дүнтэй нийцүүлэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тодорхойлж УИХ-аар батлуулахыг Засгийн газарт үүрэг болгон, хэрэгжилтийн явцад 5 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, УИХ-д танилцуулахаар тусгасан байна.

Монгол улсад Төрийн албаны төв байгууллагын 2023 онд гаргасан нэгдсэн тоо бүртгэлээр 4,239 төрийн байгууллагын 226,496 төрийн албан хаагч байгаагаас Хөвсгөл аймагт 208 төрийн байгууллагын 7,959 төрийн албан хаагч бүртгэгдсэн байна. Үүнээс:

- Төрийн улс төрийн албан хаагч 226 /2.8%/,
- Төрийн захиргааны албан хаагч 846 /10.6%/,
- Төрийн тусгай албан хаагч 65 /0.8%/,
- Төрийн үйлчилгээний албан хаагч 6,822 /85.7%/, байна.

Хөвсгөл аймгийн төрийн албан хаагчийн тоог 2013-2023 оны хүн амын тоо, Монгол улсын төрийн албан хаагчийн тоотой харьцуулж хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 1

№	Он	Монгол Улсын нийт хүн амын тоо	Нийт төрийн албан хаагчийн тоо	Хөвсгөл аймгийн хүн амын тоо	Хөвсгөл аймаг дахь төрийн албан хаагчийн тоо	Төрийн албан хаагчийн эзэлж буй хувь	
						Хөвсгөл аймгийн нийт хүн амд	Нийт төрийн албан хаагчдад
1	2013	2,930,277	169,448	125,896	6,304	5.0	3.7
2	2014	2,995,949	183,601	126,029	6,266	4.9	3.4
3	2015	3,061,600	186,458	128,159	6,644	5.1	3.6
4	2016	3,119,935	188,974	129,957	6,630	5.1	3.5
5	2017	3,177,899	192,475	132,146	6,680	5.0	3.5
6	2018	3,238,479	193,557	134,371	6,503	4.8	3.4
7	2019	3,191,684	198,463	134,318	6,648	4.9	3.3
8	2020	3,253,283	205,011	136,058	7,171	5.2	3.5
9	2021	3,312,275	208,864	137,628	7,263	5.2	3.5
10	2022	3,457,548	225,205	137,969	8,037	5.8	3.6
11	2023	3,504,741	226,496	136,885	7,959	5.8	3.5

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны мэдээ, Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлангууд

Хүснэгтээс харахад Хөвсгөл аймгийн төрийн албан хаагчийн тоо 2013 оноос 2023 онд 1.7 мянгаар нэмэгдэж аймгийн хүн амд эзлэх хувь 0.8 хувиар өссөн бол Монгол улсын нийт төрийн албан хаагчдад эзлэх хувь 0.2 хувиар буурсан байна.

Хөвсгөл аймгийн Төрийн албан хаагчдын жендерийн харьцааг 2016-2023 оны хооронд харуулсан хүснэгтэн мэдээллээс үзэхэд Хөвсгөл аймгийн төрийн албан дахь эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт 2016 оноос 2023 онд 4 хувиар өссөн байна. /Хүснэгт №2/

Хүснэгт 2

№	Он	Хөвсгөл аймгийн төрийн албан хаагчдын тоо	Үүнээс			
			Эрэгтэй	Эзэлж буй %	Эмэгтэй	Эзэлж буй %

1	2016	6,630	2,313	34,89%	4,317	65,11%
2	2017	6,680	2,310	34,58%	4,370	65,42%
3	2018	6,503	2,158	33,18%	4,345	66,82%
4	2019	6,648	2,256	33,94%	4,392	66,06%
5	2020	7,171	2,319	32,34%	4,852	67,66%
6	2021	7,263	2,299	31,65%	4,964	68,38%
7	2022	8,037	2,495	31,04%	5,542	68,96%
8	2023	7,959	2,465	30,97%	5,494	69,03%

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны тайлангууд

БҮЛЭГ 1:

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР БАРИМТЛАХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАН БАТЛААГҮЙ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭГ БОДИТ БАЙДАЛД НИЙЦҮҮЛЭН ХИЙДЭГГҮЙ БАЙНА.

1.1. Хөвсгөл аймгийн хэмжээнд төрийн байгууллагын хүний нөөцийн чиглэлээр мөрдөх стратеги төлөвлөгөө батлаагүй, бодлогын зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын бүх талын оролцоог хангаж ажиллаагүй байна.

1.1.1 Хөвсгөл аймгийн Засаг дарга нь төрийн албаны хүний нөөцийн чиглэлээр стратеги төлөвлөгөө батлаагүй байна.

Монгол улсын хэмжээнд Төрийн байгууллагын хүний нөөцийн талаар тусгайлан баримтлах бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна. Харин Монгол улсын дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд хүний нөөцийн чиглэлээр авч хэрэгжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020, 2020-2024-т 11 арга хэмжээг тусгасан байна.Үүнд:

- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд-2 арга хэмжээ
- Алсын хараа – 2050 хөтөлбөрт-23 арга хэмжээ
- Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020, 2020-2024 хөтөлбөрт – 11 арга хэмжээ

Эдгээр бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, агентлагуудын хувьд төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг батлан, тухайн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хүний нөөцийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусган, хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагуудын хүний нөөцийн чиглэлээр хэрэгжүүлж ажиллах дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан батлаагүй байна. Энэ нь Төрийн албаны тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийн 53 дугаар зүйлийн 53.1-т “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасанд нийцэхгүй байна. *Шийдвэрлэлт: Хөвсгөл аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн.*

Төрийн албаны хүний нөөцийн чиглэлээр баримтлах бодлогын баримт бичиггүй, урт хугацаанд баримтлах стратеги төлөвлөгөө боловсруулан батлаагүй, зөвхөн төрийн байгууллагын албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжруулах, сургалт, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд бодлого хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.1.2 Төрийн байгууллагууд зохион байгуулалтын бүтцийг мөрдөж ажилласан байна.

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 02 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан байна.

Уг хөтөлбөрийн хүрээнд хэвтээ бүтцийн байгууллага болох сумын засаг дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулж, хөтөлбөрийг хэрэгжүүлж тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж, үр дүнг тооцож хэвшсэн байна.

Харин босоо бүтэцтэй байгууллагуудын хувьд аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулж, жил бүр хэрэгжилтийг тайлагнаж, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнээр үнэлүүлэн, дүнг Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст нэгтгүүлж хэвшсэн байна.

1.1.3 Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоог хангаж ажиллаагүй, биелэлтэд ахиц, дэвшил гараагүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар аймгийн Засаг дарга нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн хүрээнд үйл ажиллагааны хөтөлбөрийнхөө биелэлтийг зохион байгуулж хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.

Аймгийн Засаг даргын 2013-2023 оны үйл ажиллагааны тайлан, хөтөлбөрийн биелэлт, төрийн байгууллагуудын хөтөлбөрийн хэрэгжилтийг ирүүлсэн байдалд хяналт хийхэд сумдын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлагуудаас авч нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас хэрэгжилтийг бүрэн хэмжээнд авч ажиллаагүй байна. Тухайлбал:

Хөвсгөл аймгийн төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын дарга захирал нартай гэрээ байгуулж, дүгнэж ажилладаг гэж байгаа боловч аудитын явцад баримт, материал олдохгүй байгаа нь үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт бодит эсэх нь эргэлзээтэй нөхцөл байдалд хүргэж байна.

Засаг даргын үйл ажиллагааны 2013-2023 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-үнэлгээний дүнг харуулбал дараах байдалтай байна.

/Хүснэгт №3/

Он	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн албаны чиглэлээр туссан зорилтын үнэлгээ /хувиар/		60.3	71.5	86.0	56.4	79.0	94.6		81.5	81.5	81.5

/Тайлбар: 2013, 2020 оны хяналт шинжилгээ үнэлгээний тайлан дүгнэлтийг шалгаагдагч байгууллага гаргаж ирүүлээгүй/

Хүснэгтээс харахад Хөвсгөл аймгийн засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2014-2016 онд 86 хувьтай, 2017-2019 онд 94.6 хувьтай, 2021-2023 онд 81.5 хувьтай үнэлж, 2013, 2020 онуудын үнэлгээний тайланг ирүүлээгүй байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2013-2023 оныг хүртэл ахисан үнэлгээтэй харагдах боловч сүүлийн 4 жилийг авч үзэхэд биелэлтэд ахиц дэвшил гараагүй байна.

Иргэд, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, төрийн албаны зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх зорилтыг хэрэгжүүлээгүй, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоог хангаагүй байна.

1.1.4 Төрийн байгууллагын хүний нөөцийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг бодитоор тооцож, үнэлгээгүй байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс хяналт-шинжилгээ, үнэлэх чиг үүрэгтэй байна.

Аудитаар хэлтэс, агентлагуудын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг түүвэрлэн авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хэвшээгүй, үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг тогтмол авч ажиллаагүй байна. Энэ нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтний албан

- тушаалын тодорхойлолтын 1 дүгээр зорилтын 1-т "Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх", 2-т "Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна. Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн.
2. Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул сумдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан төрийн байгууллагын хүний нөөцийн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг өөрсдөө үнэлж, аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст нэгтгүүлдэг байна.
3. Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь ерөнхий газартаа хяналт-шинжилгээ, үнэлгээний газартай бөгөөд 2 жил тутамд 1 удаа төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулж үнэлдэг байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байгаа тогтолцооны хувьд авч үзвэл Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Засаг даргын ажлын албаны хэлтэс хяналт-шинжилгээ үнэлгээ хийж байгаа нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хараат бус байх зарчимд нийцэхгүй байгаа бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ бодит бус байх эрсдэлийг үүсгэж байна.

Аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь хэлтэс, агентлаг байгууллагын өөрсдийн үнэлж ирүүлсэн тайлан мэдээг нэгтгэн хүлээн авч байгаа боловч төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд тусгайлан үнэлгээ хийж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмжийг өгч хэвшээгүй байна.

1.2. Төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд нөөцийн хуваарилалтыг жигд хүртээмжтэй байдлаар хийх бодлого баримтлаагүй байна.

1.2.1 Төрийн үйлчилгээний салбар хүний нөөцийн дутагдалд орсон байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу төрийн албаны нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөл хариуцан хэрэгжүүлж байна.

Төрийн албаны зөвлөлийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг орон нутагт Төрийн албаны салбар зөвлөл хариуцан гүйцэтгэж байна.

Төрийн албаны нөөц бүрдүүлэх зорилгоор төрийн албаны ерөнхий шалгалтыг улиралд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, Хөвсгөл аймгаас төрийн албаны ерөнхий шалгалт өгч, нөөцөд бүртгэгдсэн нийт 935 иргэн, одоогийн байдлаар хүчинтэй байгаа нөөцөд 459 иргэн байна. Үүнийг он оноор авч үзвэл дараах байдалтай байна.

№	2019	2020	2021	2022	2023	2024	Нийт
Иргэний тоо	42	156	278	122	220	117	935

Хүснэгтээс харахад жил ирэх тусам нөөцөд бүртгэгдэж байгаа

иргэдийн тоо өссөн үзүүлэлттэй байна.

Аудитаар төрийн захиргааны байгууллагын сул орон тооны талаар судалгааг түүвэрлэн авч үзэхэд 2020 оноос хойш 5 жил нөхөгдөөгүй, 2022 оноос хойш 3 жил нөхөгдөөгүй сул орон тоо байгааг дараах хүснэгтээр харуулав:

Хүснэгт № 4

№	Байгууллагын нэр	Сул орон тоо	Албан тушаал	Шалтгаан тайлбар	Авсан арга хэмжээ
Төрийн захиргааны байгууллага					
1	Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	8	Байгаль хамгаалагч /Цагаан-Уул, Цэцэрлэг сум 2022 оноос хойш/	Төрийн албан хаагчийн ерөнхий шалгалт болон тусгай шалгалтад тэнцэхгүй байгаагаас байгаль хамгаалагчаар ажиллах нөөц байхгүй, мөн 2024 оны 6 сараас байгаль хамгаалагчийн албан	Ерөнхий шалгалтад тэнцсэн болон гэрээт байгаль хамгаалагчийг шалгалт зарлагдах хүртэл хугацаанд нөхөн томилж ажилласан байна.

				тушаалын тодорхойлолт дэс түшмэлийн ангилалд шилжиж мэргэжил заасан тул мэргэжлийн индекс таарахгүйгээс байгаль хамгаалагчаар ажиллах мэргэжилтэй боловсон хүчин дутмаг болсон байна.	
2	Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	3	Газрын даамал /Рэнчинлхүмбэ сум 2020 оноос хойш/	Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтад тэнцдэггүй.	Төрийн албаны салбар зөвлөлд захиалга хүргүүлсэн.
3	Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газар	5	Сумын нийгмийн даатгалын байцаагч	Сул орон тоог зарлуулсан байна.	Төрийн албаны салбар зөвлөлд захиалга хүргүүлсэн.
Дүн		16			
Төрийн үйлчилгээний байгууллага					
Боловсрол	72	Мэргэжлийн багш	Тухайн мэргэжлээр төгсөж байгаа боловсон хүчин байхгүй, орон нутагт ажиллах сонирхолгүй.	Ижил мэргэжлийн багш нар нэмэлт цагаар заалгах чиглэлийг өгч цаашид мэргэжлийн багшаар хангахад багш мэргэжлийн бус хүмүүсийг курсээр бэлтгэх саналыг Боловсролын яаманд хүргүүлж ажиллаж байгаа.	
Соёл	7		Орон нутагт ажиллах сонирхолгүй.	Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч-5	
Эрүүл мэнд	23	Их эмч,	Сул орон тооны мэдээллийг Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.	Тухайн ЭМБ-уудаас улирал бүр сул орон тооны захиалгыг хүлээн авч цахимд нээлттэй байршуулан ажиллаж хүний нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Сумын ЭМТөвийн дарга нартай батламж байгуулан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Аймгийн Засаг даргатай-Сумын Засаг дарга нартай гэрээ байгуулах заалтад Хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх 1 заалтыг оруулан ажилласан.	
Дүн		102			
Нийт дүн		118			

Хүснэгтээс харьцуулан харахад:

- ✓ Төрийн захиргааны байгууллагын хувьд орон нутаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн хяналт хэрэгждэг учраас сул орон тоо харьцангуй бага байгаа ч 3-5 жил нөхөгдөөгүй албан тушаалын хувьд хүний нөөцийн чадавх сул, орон нутагт сэлгэн, шилжүүлэн ажиллахад нийгмийн баталгаа, амьдрах орчин нөхцөлөөр хангагдахгүй, тухайн чиглэлээр шинээр боловсон хүчин бэлтгэгдэхгүй, энэ талаар аймаг орон нутгийн эрх бүхий байгууллагууд бодлогын түвшинд асуудлыг шийдэж ажиллаагүйтэй холбоотой байна.
- ✓ Төрийн үйлчилгээний салбарын хувьд төрийн албаны тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй, хяналтаас гадуур, салбарын бодлого хангалтгүй зэрэг шалтгаанаар боловсон хүчний дутагдалд орсон байна. Үүнээс шалтгаалан тухайн салбарын үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж орон нутагт буурах эрсдэлийг бий болгож байна.

Төрийн үйлчилгээний салбарын хувьд төрийн албаны тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй, хяналтаас гадуур, салбарын бодлого хангалтгүй зэрэг шалтгаанаар боловсон хүчний дутагдалд орсон байна.

1.2.2 Төрийн байгууллагын үйлчилгээний ил тод нээлттэй байдал хангалтгүй байна.

Монгол улсад төрийн байгууллагын 440 төрлийн үйлчилгээг ил тод нээлттэй байдлаар цахим системүүдээс шууд авах боломж бүрдсэн байна. Тухайлбал:

1. Иргэний лавлагаа бүртгэл, эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой мэдээллийг E-Mongolia цахим үйлчилгээний цахим системээс,
2. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээтэй холбоотой мэдээллийг E-health цахим системээс,
3. Худалдан авах ажиллагааны мэдээллийг tender.gov.mn цахим системээс,
4. Татвартай холбоотой мэдээллийг Etax.mta.mn цахим системээс,
5. Газартай холбоотой мэдээллийг Egazar.gov.mn газрын цахим системээс,
6. Зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг license.mn цахим системээс тус тус авах боломж бүрджээ.

Дээрх цахим системүүдээс иргэн өөрийн хүссэн үйлчилгээг авах боломж бүрдсэн боловч орон нутгийн түвшинд хуулийн дагуу олгодог зөвшөөрлүүд license.mn цахим системд холбогдоогүй /жишээ нь: архи согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл олгох гэх мэт/ байна.

Төрийн үйлчилгээ цахим системд шилжиж, шат дамжлагыг цөөлсөн ч гэсэн үйлчилгээний үр дүнг тухайн системээр ил тод мэдээлдэггүй байна. Жишээлбэл:


Өмнө нь газар эзэмшиж байгаагүй иргэн Egazar.gov.mn цахим системээр газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал өгч газар эзэмших хүсэлт гаргасан ч дэмжигдээгүй гэсэн шалтгаанаар татгалзсан боловч тухайн онд өөр иргэдэд газар эзэмшүүлэхээр газар зохион байгуулалтын төлөвлөгөө гаргаж газар эзэмшүүлсэн байна. Энэ тохиолдолд татгалзсан шалтгааныг тодорхой заагаагүй, зөвхөн дэмжигдээгүй гэсэн шалтгаанаар цахим хариуг өгч байгаа нь шийдвэрийн ил тод байдал хангалтгүй байгааг харуулж байна.

Орон нутгийн байгууллагуудын хувьд үйл ажиллагааны тайлан мэдээ, цаг үеийн шинжтэй мэдээ мэдээллийг шинэчлэх, цахим хуудасны баяжуулалт хангалтгүй байна.

1.2.3 Төрийн үйлчилгээний салбарын хүний нөөцийг жигд хүртээмжтэй байдлаар хуваарилаагүй байна.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын хувьд газар зүйн байршлаас шалтгаалж харилцан адилгүй, нэг багш, эмчид ногдох ачаалал их, боловсон хүчний дутагдалтай байгаа зэрэг шалтгаан нь үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулах эрсдэлийг бий болгож байна. Эрүүл мэндийн салбарын норматив болон бодит нөхцөл байдлыг графикаар харуулбал:

/График № 1/



Хөвсгөл аймгийн Их эмчийн орон тоо нийт 102 байх ёстойгоос одоо ажиллаж байгаа нь 83 эмч байгаа нь 1 эмчид өдөрт 7 хүн ам илүү ногдож ажлын ачаалал үүсгэж, нөөцийн

хуваарилалтыг бүрэн удирдаж ажиллаагүйг харуулж байна. Ажлын ачаалал үүссэнээр эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж буурах эрсдэлийг дагуулж байна.

Аудитаар Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул сумдын төрийн байгууллагуудад ажиллахад боловсрол, эрүүл мэндийн салбарын мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байсан бөгөөд сумын их эмчийн ажлыг бага эмч хавсран гүйцэтгэж, тухайн сул орон тоог нөхөх талаар бодлого хэрэгжүүлэгч байгууллагад санал хүргүүлсэн боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна. Уг шалтгааныг судлан үзэхэд алслагдсан суманд очиж ажиллах сонирхолтой залуу боловсон хүчин байхгүй, амьдрах орчин, нийгмийн баталгаа хангалтгүй, цалин хөлс нэмэгдэл урамшуулал нь аймгийн төвийн эмчтэй адил, ачаалал их зэрэг нь суманд очиж ажиллах хүний нөөцийг татах тууштай бодлого байхгүйг харуулж байна.

Боловсролын үйлчилгээний чанарын зөрүүтэй байдлаас шалтгаалан иргэд харьяалах газартай үйлчлүүлэхгүй байх, сайн үйлчилгээтэй гэж үзсэн газартай ачаалал үүсгэх хандлагатай байна. Жишээ нь: Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн сургалт сайн гэсэн үндэслэлээр анги дүүргэлт нь 35-аас дээш хэмжээнд байхад өөр алслагдсан сургуулиудад анги дүүргэлт харьцангуй бага байна.

Боловсролын салбарын 1 багшид ногдох ачааллыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 5

№	Төрийн үйлчилгээ	Стандартаар тогтоосон хүүхдийн тоо	Бодит анги дүүргэлт	Зөрүү буюу ачаалал
1	Ерөнхий боловсролын сургууль	30-35	40-45	10
2	Сургуулийн өмнөх боловсрол	20-25	45-55	25-30

Дээрх хүснэгтээс харахад Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын сургуулийн нийт хүүхдийн тоог нийт багшийн тоонд харьцуулахад 1 багшид ногдох хүүхдийн тоо 23 байна. Төвлөрөл сургалтын чанараас шалтгаалан аймгийн төвийн сургуулиудад анги дүүргэлт 40-45 буюу нэг багшид ногдох стандарт 10 хүүхдээр хэтэрсэн байна.

Сургуулийн өмнөх боловсролын 1 багшид анги дүүргэлт 45-55 хүүхэд байгаа нь ажлын ачаалал, боловсролын үйлчилгээний хүртээмж, нөөцийн хуваарилалт хангалгүй байгааг илтгэж байна.

1.3 Эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийдэггүй, төрийн албан хаагчийг тогтвортой ажиллуулах нийгмийн баталгаагаар хангагдаагүй, төрийн албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлээгүй, улс төрийн нөлөөнөөс ангид байх зарчим хэрэгжихгүй байгаагаас үзэхэд хүний нөөцийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлж чадаагүй байна.

1.3.1 Эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ аваагүй байна.

Төрийн байгууллагын чиг үүрэгт дараах эрх бүхий этгээд шинжилгээ хийх чиг үүрэгтэй байна. Үүнд:

- ❖ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах
- ❖ Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмын 3.1.2-т “Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх ажлыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан заавар, аргачлалын хүрээнд зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх”

Аймгийн Засаг дарга төрийн байгууллагуудын чиг үүрэгт шинжилгээ хийх ажлын хэсгийг Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын 6³-д босоо удирдлагатай байгууллагын хувьд харьяалах яамны дэргэд, орон нутгийн байгууллагуудын хувьд Засаг даргын дэргэд байгуулж, Төрийн албаны зөвлөлөөс мэргэшил, арга зүйн зөвлөгөө авч гүйцэтгэхээр заасан байна.

Монгол улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт, аймгийн Засаг даргын 2014-2023 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт болон үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн байгууллагуудын чиг үүргийг боловсронгуй болгох, шинжилгээ хийх зорилтыг тусгасан байна.

Аудитаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцахад 2019 онд аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдийн чиг үүрэгт ажлын байрны шинжилгээ 1 удаа хийснийг эс тооцвол төрийн байгууллага, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах ажлыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;” гэж заасантай нийцэхгүй байна.

Аудитад хамрагдсан төрийн байгууллагын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг түүвэрлэн хяналт хэрэгжүүлэхэд дараах байдалтай байна.

Одоо мөрдөж байгаа хууль, журамд зааснаар чиг үүргийн шинжилгээ хийсний үндсэн дээр төрийн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсон тохиолдолд албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах зохицуулалттай байна.

Аймгийн Засаг даргын чиг үүргийн шинжилгээ хийх ажлын хэсгийн дүгнэлтгүйгээр Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 334, 335 дугаар тогтоолуудаар АИТХ-ын ажлын албаны болон аймгийн ЗДТГ-ын газар хэлтсийн дарга нарын болон зарим албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтын дахин шинэчилж баталсан байна. Ингэж газар, хэлтсийн дарга нарын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлахдаа албан тушаалын чиг үүрэгт шууд хамааралгүй мэргэжлийн шалгуурыг хэт олноор зааж өгсөн байна. **Тухайлбал:**

1. АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтод 12, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтод 13, Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтод 11, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтод 10, Орон нутгийн өмчийн газрын даргын албан тушаалын тодорхойлолтод 9 мэргэжлийн шаардлага зааж 2-4 мэргэжлийн шаардлага нэмсэн байна.
2. АИТХ-ын ажлын албаны Хурлын хуралдаан, Зөвлөл хариуцсан ахлах мэргэжилтний мэргэжлийн шалгуурт - хөдөө аж ахуй/081/, мал эмнэл зүй/084/, инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт/07/ чиглэлийн мэргэжлүүд,
3. АИТХ-ын ажлын албаны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, шашны байгууллага, Улаан загалмайн хороо, ЭБАТ хариуцсан мэргэжилтний мэргэжлийн шалгуурт - байгалийн шинжлэх ухаан, математик, статистик/05/, инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт/07/, хөдөө аж ахуй, ой загасны аж ахуй, мал, эмнэл зүй /08/, онцгой байдал, гамшгаас хамгаалах алба /103205/ зэрэг мэргэжлийн шалгуур заасан байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах журам” нь төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалтны албан тушаалын тодорхойлолт боловсруулахаар зохицуулагдсан бөгөөд

³ Чиг үүргийн шинжилгээ хийх, дахин хуваарилах санал боловсруулах үүрэг бүхий техникийн ажлын хэсгийг (цаашид “ажлын хэсэг” гэх) холбогдох төрийн захиргааны төв байгууллага, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд байгуулна.

төрийн үйлчилгээний байгууллагын хувьд төсвийн шууд захирагчийн албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн саналыг авсны үндсэн дээр томилох эрх бүхий этгээд батална гэсэн ганц заалтаар зохицуулсан байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн даргатай уулзалт хийж салбарын хэмжээний асуудлын талаар ярилцахад боловсон хүчний дутагдалтай байгаа боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын хувьд албан тушаалын тодорхойлолт боловсруулж мөрдөх аргачлал нь өөр өөр байгааг дурьдаж байсан. **Тухайлбал:**

- ❖ Эрүүл мэндийн салбарын хувьд 2020 оноос хойш 2024 оны 04 дүгээр сар хүртэл эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулахдаа өөрсдийн шаардлагаар боловсруулж ирсэн байна. Энэ оны 04 дүгээр сард эрүүл мэндийн даргын сул орон тоог зарлахад Төрийн албаны зөвлөлөөс Хөвсгөл болон Дорноговь аймгийн шалгуур өөр байгаа шалтгаанаар зогсоосон байна. Иймд эрүүл мэндийн салбар албан тушаалын жишиг тодорхойлолт боловсруулахаар ажиллаж байгаа учраас эрүүл мэндийн төвийн даргын сул орон тоог зарлаагүй, зогсоосон байгаа,
- ❖ Соёлын салбарын хувьд ажлын байрны жишиг тодорхойлолт мөрдөж байгаад одоо хүчингүй болж, аймаг сумандаа боловсруулалтаа хийж батлуулах ерөнхий чиглэл өгсөн байгаа ч манай аймаг одоо болтол саналаа боловсруулж хэлэлцүүлээгүй байна гэв.

Үүнээс дүгнэхэд төрийн үйлчилгээний салбарын удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журамгүй, баримтлах жишиг албан тушаалын тодорхойлолт байхгүй, салбар хоорондын уялдаа хангагдаагүй, Төрийн албаны тухай хууль нь төрийн үйлчилгээний албан хаагчийг хуулийн үйлчлэлд хамааруулаагүйгээс хяналт тавих, нэгдсэн нэг удирдлагаар хангах эрх зүйн орчин бүрдээгүй байна.

1.3.2 Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллах нийгмийн баталгаагаар бүрэн хангаж ажиллаагүй байна.

Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрүүдийг Хөвсгөл аймгийн Засаг даргын 2009 оны 266, 267 дугаар, 2017 оны А/440 дүгээр, 2023 оны А/457 дугаар захирамжуудаар тус тус баталж хэрэгжүүлсэн байна.

Сургалтын дэд хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчдыг байгууллагын дотоод болон дээд шатны байгууллага, удирдлагын академийн сурталтуудад тасралтгүй хамруулж ажиллажээ. Тухайлбал: Шинэчилсэн Төрийн албаны тухай хуульд заасан мэргэшүүлэх багц сургалтад төсвийн хөрөнгө оруулалтаар сургалтын төлбөрийг төлж 230 албан хаагчийг сургасан байна.

Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн 2013-2023 онд ажлын байрны орчин нөхцөлийг тасралтгүй сайжруулах, техникийн эд хогшлыг сайжруулах хөрөнгө оруулалтуудыг хийж ирсэн ба төрийн албан хаагчдын гол нийгмийн баталгаа болсон цалин хөлсийг УИХ, Засгийн газраас тогтоосон хувь хэмжээгээр тасралтгүй олгож ирсэн байна. Төрийн албаны цалингийн хэмжээ нь 2013-2023 оны хугацаанд 6 удаа өөрчлөгдөн нэмэгдэж, төрийн захиргааны хамгийн бага цалингийн хэмжээгээр илэрхийлбэл 289,377 төгрөгөөс 1,100,000 төгрөг хүртэл 3.8 дахин өссөн байна.

Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтээс үзэхэд орон нутагт дутагдалтай байгаа боловсон хүчнийг ирүүлж ажиллуулахад уг хөтөлбөрийн зорилт чиглэгдэхгүй, зөвхөн ажиллаж байгаа албан хаагчид руугаа чиглэсэн байдалтай байгаа сул тал ажиглагдаж байна.

1.3.3 Төрийн байгууллагууд гарсан сул орон тоог ил тод мэдээлээгүй, үүссэн сул орон тоог бүрэн нөхөж ажиллаагүй байна.

Төрийн байгууллагад гарсан сул орон тоог Төрийн албаны тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дугаар хамтарсан тушаалын

хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын дагуу нөхөн томилохоор хуульчилсан байна.

Төрийн байгууллагын сул орон тоог нөхөх дээрх хууль, эрх зүйн актыг хэрэгжүүлэгч нь орон нутаг дахь төрийн албаны салбар зөвлөл /цаашид ТАСЗ гэх/ юм. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 138 дугаар тогтоолоор Хөвсгөл аймаг дахь төрийн албаны салбар зөвлөлийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна.

Төрийн албаны салбар зөвлөлийн ажиллах чиг үүргийг 2013-2018 оны хооронд Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-аар тодорхойлж, түүнээс хойш 2019 оны 59 дүгээр тогтоолоор тус журмыг шинэчлэн баталж, одоог хүртэл мөрдөн ажиллаж байна.

Салбар зөвлөлийн ажиллах чиг үүргийн хүрээнд төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг “Open-Exam” шалгалтын цахим системээр явуулж хэвшсэн байна. Хөвсгөл аймгийн хэмжээнд 2024 оны хагас жилийн байдлаар 459 иргэн нөөцөд бүртгэлтэй байна.

Төрийн жинхэнэ албаны хувьд: Хөвсгөл аймгийн хэмжээнд сүүлийн 5 жилд бий болсон сул орон тоог нөхсөн болон нөхөгдөөгүй талаар мэдээллийг албан тушаалын ангиллаар түүвэрлэн авч үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт № 6

Он	Үзүүлэлт	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаал	Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаал	Төрийн үйлчилгээний төсвийн шууд захирагч	Нийт
2020	Сул орон тоо	5	43	15	63
	Нөхсөн	5	21	2	28
	Нөхөгдөөгүй	0	22	13	35
2021	Сул орон тоо	14	107	22	143
	Нөхсөн	9	61	10	80
	Нөхөгдөөгүй	5	46	12	63
2022	Сул орон тоо	23	163	31	217
	Нөхсөн	12	106	17	135
	Нөхөгдөөгүй	11	57	14	82
2023	Сул орон тоо	19	208	28	255
	Нөхсөн	9	142	10	161
	Нөхөгдөөгүй	10	66	18	94


Эх сурвалж: Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн жил бүрийн эцсийн үйл ажиллагааны тайлан

Дээрх хүснэгтээс харахад сүүлийн 4 жилийн байдлаар он тус бүрд үүссэн сул орон тоог хангалттай хэмжээнд нөхөж ажиллаж чадаагүйг харуулж байна. Тухайлбал: 2020 онд үүссэн сул орон тооны 55,6%-ийг, 2021 онд үүссэн сул орон тооны 44%-ийг, 2022 онд үүссэн сул орон тооны 37,7%-ийг, 2023 онд үүссэн сул орон тооны 36,8%-ийг нөхөж ажиллаж чадаагүй байна.

Мөн сонгуулийн дараах жилд сул орон тоо ихээр үүсэж байгаа нь улс төрийн нөлөөнөөс шалтгаалан төрийн албан хаагчийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэхгүй байгааг харуулж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу Төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч нөхөгдөөгүй үлдсэн орон тоог тухайн байгууллагаас захиалга ирүүлсний дараа дахин зарладаг байна. Захиалга ирүүлсэн сул орон тоо нөхөгдөөгүй бол нөхөгдөх хүртэл сонгон шалгаруулалтыг явуулах процессыг журамд тодорхойлон тусгаагүйгээс дахин захиалга ирүүлэх хүртэл цаг хугацааг алдаж байна.

Төрийн жинхэнэ албаны сул орон тоо үүсэх шалтгаан болон түүнийг нөхөх процессыг дараах схемээр харуулав:



Схемд үзүүлснээр Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2⁴ дахь заалт хэрэгжихгүй байгаа нь төрийн байгууллагын хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал алдагдсан, хариуцлагын арга хэмжээ хэрэгжихгүй байгаагаас тухайн зөрчил давтан гарсаар байна.

Төрийн байгууллагад сул орон тоо гарсан тохиолдолд хуульд заасан хугацаанд нийтэд мэдээлээгүй, Төрийн албаны салбар зөвлөлд 21 хоногийн дотор захиалгыг ирүүлэхгүй хоцроож ирүүлсэн, сул орон тоог зарлуулаагүй удаан хугацаанд сул хэвээр хадгалсан тохиолдол бүрд салбар зөвлөл нь шаардлага тавьж, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Дээрх зөрчил нь Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1⁵-т, 3.6.4⁶- дэх заалтыг зөрчсөн байна.

Төрийн албаны сул орон тоо нөхөгдөхгүй байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- ❖ Цалин хангамж бага
- ❖ Орон нутагт очиж ажиллахад амьдрах орчин нөхцөлөөр хангагдахгүй
- ❖ Албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуур өндөр
- ❖ Тухайн мэргэжлээр төгсөж байгаа боловсон хүчин байхгүй
- ❖ Орон нутгийн алслалт, нийгмийн баталгаа
- ❖ Тухайн байгууллага нь сул орон тоог нийтэд мэдээлэх сонирхолгүй, хавсран гүйцэтгүүлж байх зэргээс шалтгаалж байна.

Тухайлбал:

- ❖ Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Засаг даргын тамгын газрын дарга, бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Ханх сумын улсын бүртгэгчийн сул орон тоог 7 хоногийн дотор нийтэд мэдээлээгүй, хууль, журмын дагуу захиалга өгч, сонгон шалгаруулалт зарлуулаагүй байна. Цагааннуур сумын 2 орон тоо нь 2024

⁴ Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

⁵ "Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны тухай хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, энэ талаар харьяалах байгууллагад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх"

⁶ "Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих"

оны 5 дугаар сард бий болсон байхад 2024 оны 9-р сар хүртэл нийтэд мэдээлээгүй, захиалга хүргүүлээгүй байсан. Дээрх зөрчил нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2⁷ дахь заалтыг зөрчсөн байна.


- ❖ Хөвсгөл аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь нягтлан бодогчийн ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаагүй, шууд томилгоо хийсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 3.2⁸ дахь заалтыг зөрчсөн байна.

Сул орон тоог Төрийн албаны тухай хуульд заасан хугацаанд нийтэд мэдээлээгүй, сул орон тоо зарлуулахгүйгээр хавсран гүйцэтгүүлж байгаа тохиолдолд тавих хяналт сул, хариу арга хэмжээ авч ажиллаагүйгээс зөрчил давтан гарсаар байна. Төрийн үйлчилгээний албаны сул орон тоог нөхөх үйл явцыг хууль, журмаар тодорхойлж өгөөгүйгээс төрийн үйлчилгээний албаны сул орон тоо нөхөгдөх үйл явц удаашралтай байна.

1.3.4 Төрийн албаны эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр 28 төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учирсан 152.4 сая төгрөгийн хохирол барагдаагүй байна.

Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг дараах хууль эрх зүйн орчны хүрээнд хэрэгжүүлдэг байна. Үүнийг схемээр харуулбал:

/Схем 2/



Төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд төр хохирлыг барагдуулах, төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх процесс эндээс харагдаж байна. Энэ нь нэгдүгээрт “Төр-Иргэн” буюу төрийн эрх бүхий албан тушаалтан буруутай шийдвэр гаргасан учраас эхлээд төр иргэнийг хохиролгүй болгох, хоёрдугаарт тухайн буруутай албан тушаалтан төрийг хохиролгүй болгох зарчмын үйлчлэл юм.

Хөвсгөл аймгийн хэмжээнд Төрийн байгууллагын ажил олгогчийн буруутай шийдвэрээс ажлаас халагдаж, шүүхээр шийдвэрлэж, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлсэн байдал дараах байдалтай байна.

⁷ “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ”

⁸ “Эрх бүхий албан тушаалтан нь төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийг нээлттэй сонгон шалгаруулж, саналаа дараах материалын хамт энэ журмын 3.1-д зааснаар зөвшилцөх албан тушаалтанд хүргүүлнэ”

Он	Хүний тоо	Нэхэмжлэлийн шаардлага	Төсвөөс төлсөн дүн	Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлсэн дүн	Төрд учирсан хохирол барагдаагүй дүн	Тайлбар
2017	2	6,322.6	6,322.6	-	6,322.6	
2018	2	4,295.0	4,295.0	2,800.0	1,495.0	
2019	4	64,220.3	64,220.3	-	64,220.3	
2020	10	35,335.3	27,735.3	9,257.9	18,477.4	7,000.0 төгрөгийг ХЗДХЯ-аас төлсөн гэх
2021	7	33,024.2	33,024.2	2,791.6	30,232.6	
2022	4	41,154.8	31,625.2		31,625.2	
2023	4 нэхэмжлэхээс 3-ыг хэрэгсэхгүй болгож, 1 нэхэмжлэхийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгосон байна.					
2024	1 нэхэмжлэх гаргасныг шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон байна.					
Нийт	28	184,352.2	167,222.6	14,849.5	152,373.1	

Хүснэгтээс харахад 2020 оны сонгуулийн үр дүнд эрх баригч нам солигдсоноос хойш эрх зөрчигдсөн төрийн албан хаагчийн тоо, төрд учирсан хохирлын тоо огцом нэмэгдсэн байгааг харж болохоор байна.

Мөн 2017-2024 оны хооронд өссөн дүнгээр 28 төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд учирсан хохирол 167.2 сая төгрөг байна. Үүнээс төрийг хохиролгүй болгож нөхөн төлүүлсэн нь 14.8 сая төгрөг буюу 8.8 хувьтай байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.3-т заасан үүргийн хүрээнд Хөвсгөл аймгийн санхүүгийн хяналт аудитын алба, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Төлбөрийн актын дагуу буцаан төлөгдсөн 14.8 сая төгрөг, авлагаар тусгуулсан 56.1 сая төгрөг байгаа боловч 152.4 сая төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т “Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана” гэж заасан байгаа тул Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл нь нөхөн төлөгдөөгүй 152.4 сая төгрөгийн хохирлыг шүүхэд нэхэмжлэх гаргах саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх, энэ талаар зохих арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

Төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн тохиолдолд тухайн буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар шууд хохирлыг барагдуулах хууль эрх зүйн зохицуулалтгүй, тухайн буруутай шийдвэр гаргасан албан тушаалтанд авах хариуцлагын арга хэмжээ байхгүй, Төрийн албаны салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн 50.2-т заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүйгээс төрийн албан хаагчийн эрх зөрчигдөх, төрд хохирол нөхөн төлөгдөхгүй байх зэрэг зөрчил давтан гарсаар байна.

1.3.5 Төрийн байгууллагууд төрийн албаны хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцооны системийн мэдээллийг бүрэн оруулаагүй, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага мэдээлэлд хандах эрх орон нутагт хязгаарлагдмал байна.

Улсын хэмжээнд төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн hrm.csc.gov.mn системийг 2016 оноос хойш ашиглаж, бүрэлдэхүүн хөдөлгөөн, тухайн байгууллагын албан хаагчдын хөдлөл өөрчлөлт, бүтэц орон тоо, цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал зэрэг үндсэн мэдээллийг өөрчлөлт орсон тухай бүр хөтөлж хэвшсэн байна.

Зураг 1/



ХНУМТ цахим систем нь ТАЦНС, Portal.ndaatgal.mn, E-Mongolia.mn, ХҮР, Esisi.edu.mn, Shuukh.mn системүүдтэй мэдээлэл солилцон ажиллаж байна. Зурагт үзүүлсэн бусад системтэй мэдээлэл солилцох ажил хөгжүүлэлтийн шатанд явж байна.

ХНУМТ цахим систем нь зөвхөн улсын хэмжээний статистик тоо, мэдээг нэгтгэн гаргахаар хөгжүүлэлт хийгдэж

байгаа бөгөөд орон нутагт хандах эрх нь зөвхөн орон нутгийн хэвтээ бүтцийн байгууллагуудын албан хаагчдын мэдээллийн жагсаалт харах хэмжээнд олгогдсон байна. Үүнээс шалтгаалан орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын хүний нөөцийн мэдээлэлд цахим хяналт хийх боломж бүрдээгүй, газар дээр нь очиж цаасан суурьт баримттай тулган хяналт хэрэгжүүлэх шаардлага тулгардаг байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл нь олгогдсон эрхийн хүрээнд Алаг-Эрдэнэ, Рашаант, Тосонцэнгэл, Тариалан, Их-Уул сумын төрийн байгууллагууд, Мөрөн сумын ЗДТГ, ИТХ-ын ажлын албаны хүний нөөцийн системийг цаасан баримттай түүвэр байдлаар тулгалт хийж, нийтлэг алдаа дутагдал, түүнийг засаж сайжруулах чиглэлээр төрийн байгууллагуудад зөвлөмж хүргүүлж, хүний нөөцийн чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдын нэгдсэн мэдээлэл солилцох цахим групп бий болгож, цахим системийн хөтлөлт, шинэчлэлттэй холбоотой видео хичээлийг түгээж, тодорхой байгууллага дээр тусгайлан үүсэж буй асуудлыг Төрийн албаны зөвлөлийн Сургалт, судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн нэгжтэй холбож, асуудлыг шийдвэрлэж ажилласан байна.

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем нь төрийн байгууллагад гарсан сул орон тоо, нөөцөд бүртгэлтэй иргэдийн жагсаалт, сэлгэн, шилжүүлэн ажиллуулсан мэдээлэл, гүйцэтгэлийн үнэлгээ, шагнал урамшуулал, нийгмийн баталгаа зэрэг төрийн байгууллагын хүний нөөцтэй холбоотой чухал шаардлагатай тайлан мэдээг боловсруулах системийн хөгжүүлэлт хийгдээгүй нь хяналтыг цахимаар хэрэгжүүлэх, алдаа зөрчлийг бууруулах, төрийн байгууллагын хүний нөөцөд шаардлагатай дүн шинжилгээ хийх тоон мэдээ бэлтгэх, зөвлөн сайжруулах боломжийг хязгаарласан, зөвхөн цалин бодоход зориулж мэдээлэл бүрдүүлдэг хэлбэртэй байна.

БҮЛЭГ 2:

ХҮНИЙ НӨӨЦИЙГ СУРГАЖ, ЧАДАВХЖУУЛАН, ИРГЭДЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ОРОН ЗАЙНААС ҮЛ ХАМААРАН ЦАХИМ СИСТЕМЭЭР ХҮРГЭХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛСЭН БАЙНА.

2.1 Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийг дэмжин чадавхжуулсан байна.

2.1.1 Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааран сургаж хөгжүүлэх үйл ажиллагаанд тодорхой ахиц гарсан байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, сургалтын хөтөлбөрийн тайлангаас үзэхэд төрийн албан хаагчдад чиглэсэн дотоод болон бусад сургалтыг тасралтгүй зохион байгуулж ажилласан байна. **Тухайлбал:** Сүүлийн 2023 оны тайлангаас үзэхэд сумд болон аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, байгууллагууд ажлын байрны 645, нэгдсэн 360 удаагийн сургалт, семинар, зөвлөгөөн зохион байгуулж 161.3 сая төгрөгийн зардал гаргасан байна. Нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулахдаа сумдын албан хаагчдыг цахим хэлбэрээр оролцуулах зохион байгуулалтын хэлбэрийг ашиглаж ажилласан байна. Энэ нь цахим орчин хөгжсөнөөр төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааран сургах, суралцуулах боломжтой болсныг илтгэж байна.

2.1.2 Төрийн албан хаагчийг сэлгэн, шилжүүлэн ажиллуулах, түр орлон гүйцэтгүүлэхдээ Төрийн албаны тухай хуульд заасан шалгуурыг баримтлаагүй томилгоо хийсэн байна.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1⁹-д төрийн байгууллагад гарсан сул орон тоог нөхөх дарааллыг заасан байна.

Аудитаар сул орон тоог хууль журамд заасан процессын дагуу нөхөж байгаа эсэхэд түүвэр хяналт хийхэд дараах зөрчилтэй зүйлс илэрч байна. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргыг 2021 оны 02 дугаар сард хууль бусаар ажлаас халж, энэ хугацаанаас хойш түр орлон гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэн төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг алдагдуулж, тухайн албан тушаалд 4 жилд 5 өөр албан хаагчийг томилон ажиллуулсан байна. Мөн АЗДТГ-ын даргын сул орон тоонд сонгон шалгаруулалт хийлгэхээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн захиалгаа цуцлах гэх мэтээр дээрх албан тушаалд түр орлон гүйцэтгэгчийг ажиллуулж байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасан “мэргэшсэн, тогтвортой байх;”, 27 дугаар зүйлийн 27.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө: ...”, 27.2-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.



2. Аймгийн ЗДТГ-ын дарга, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга/өмнөх албан хаагчийг хууль бусаар ажлаас халсан нь тогтоогдсон/, Орон нутгийн өмчийн газрын дарга нарын албан тушаалд түр орлон гүйцэтгэгчдийг томилохдоо Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан тухайн албан тушаалд чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, албан хаагчаар түр орлон гүйцэтгүүлэх журмыг баримтлаагүй, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын ажлаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн сумын Засаг дарга /одоо Хяналт, шинжилгээ үнэлгээний ахлах мэргэжилтнээр гүйцэтгүүлж байгаа/ байсан албан хаагчаар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын ажлыг Татварын хэлтэст ажиллаж байсан албан хаагчаар, Орон нутгийн өмчийн газрын даргын ажлыг сумын ИТХ-ын дарга хийж байсан /түүхийн багш мэргэжилтэй/ албан хаагчаар тус тус орлон гүйцэтгүүлсэн байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг дараах журмаар түр орлон гүйцэтгүүлнэ: ...” гэж заасныг зөрчсөн байна.

3. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байхдаа Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын даргын даргын сул орон тооны тусгай шалгалтад оролцож, тэнцэн тухайн албан тушаалд томилогдоод 12 хоносон Б.Должинсорогдогийг мөн Орон нутгийн өмчийн газрын даргаар/одоо Худалдан авах ажиллагааны газрын даргаар үргэлжлүүлэн томилогдсон/, Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байхдаа Өмнөговь аймгийн Баяндалай сумын ЗДТГ-ын даргын сул орон тооны тусгай шалгалтад оролцож тэнцэн тухайн албан тушаалд томилогдоод 8 хоносон Х.Цэнд-Аюушийг Орон нутгийн өмчийн газрын даргаар шилжүүлэн

⁹ Хөвсгөл аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2013-2023 оны хөтөлбөрийн тайлан, Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааны 2013-2023 оны тайлан, мэдээнээс үзэхэд мэдлэг чадвартай албан хаагчдыг сэлгэх, шилжүүлэн ажиллуулах тохиолдол бага байна.

томилсон байна. Энэ нь төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах хэрэгцээ, шаардлага, ажлын байрны талаарх мэдээллийн санд үндэслээгүй, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцож, эсхүл тухайн байгууллагад 10 ба түүнээс дээш жил нэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийг удирдлагын санаачилгаар төрийн албаны нэг байгууллагаас нөгөө байгууллагад тэдгээрийн удирдлагын хооронд харилцан тохиролцсоны дагуу шилжүүлэн ажиллуулж болно. Тайлбар: Энэ хуулийн 44.1-д заасан албан ажлын зайлшгүй шаардлага гэдэгт тухайн байгууллагад шаардлагатай байгаа мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлэх, онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг нөхцөл, байдлыг ойлгоно.", Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр тушаалаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын 1.3-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах хэрэгцээ, шаардлага, ажлын байрны талаарх мэдээллийн санг дараах байдлаар хөтөлнө: 1.3.1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4. Хөвсгөл аймгийн Засаг дарга нь Байгаль, орчин аялал жуулчлалын газрын дарга П.Мөнхжаргалыг Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд шалгалт өгч тэнцээд удаагүй байхад Хөвсгөл аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын даргаар шилжүүлэн томилсон байна. Тухайн томилгоонд Төрийн албаны зөвлөлөөс хяналт хэрэгжүүлж, зөрчилтэй болохыг тогтоож, үүрэг өгсөн боловч тогтоолын хэрэгжилтийг хангаагүй байна.

5. Аймгийн ИТХ-ын Ажлын албаны Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байх хугацаандаа Монгол улсын Соёл, урлагийн газрын Соёлын арга хэмжээ, хэрэгжилтийн хэлтсийн даргын сонгон шалгаруулалтад орж тэнцэн 2024.07.01-ний өдөр тухайн албан тушаалд томилогдсон Б.Одончимэг/Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн/ийг 2024.07.08-ний өдөр шилжүүлэн авч Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн даргаар томилсон байна. Энэ нь төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах хэрэгцээ, шаардлага, ажлын байрны талаарх мэдээллийн санд үндэслээгүй, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцож, эсхүл тухайн байгууллагад 10 ба түүнээс дээш жил нэг албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчийг удирдлагын санаачилгаар төрийн албаны нэг байгууллагаас нөгөө байгууллагад тэдгээрийн удирдлагын хооронд харилцан тохиролцсоны дагуу шилжүүлэн ажиллуулж болно. Тайлбар: Энэ хуулийн 44.1-д заасан албан ажлын зайлшгүй шаардлага гэдэгт тухайн байгууллагад шаардлагатай байгаа мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлэх, онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг нөхцөл, байдлыг ойлгоно.", Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр тушаалаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын 1.3-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах хэрэгцээ, шаардлага, ажлын байрны талаарх мэдээллийн санг дараах байдлаар хөтөлнө: 1.3.1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар төрийн захиргааны төв, төрийн захиргааны байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог түр орлон гүйцэтгүүлэх, сэлгэн, шилжүүлэн томилохдоо шаардлага хангаагүй төрийн албан хаагчдыг томилж байна.

2.1.3 Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай төрийн албан хаагчийг сургаж, хөгжүүлсэн байна.

Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” хөтөлбөрт Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох

мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, “Хиймэл оюун ухаан ба ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай төрийн албан хаагчдыг дараах сургалтад хамруулсан байна.

Хүснэгт № 8

№	2023 он	2024 он
1	Төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэх оператор ажилтныг сургах, мэргэжлийн үр чадвартай хүний нөөц бүрдүүлэх тухай сургалтад-хэлтсийн дарга нар,	“Кибер аюулгүй байдал”-ын сургалт-Хэлтсийн дарга хамрагдлаа.
2	Цахим үр чадварын сургагч багш бэлтгэх сургалтад үйлчилгээний ахлах ажилтнууд,	И-Монголиа академиас зохион байгуулсан сургалт-Үйлчилгээний ажилтнууд хамрагдсан.
3	Цахим аймаг бодлогын зөвлөмжийн сургалт нийт албан хаагч,	Хөвсгөл аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн албан хаагчид 12 удаагийн чадавхжуулах сургалтад хамрагдлаа.
4	Төрийн Цахим үйлчилгээний Зохицуулалтын газрын даргын 2023 оны А/79 дугаар тушаалын дагуу 2023 оны 08 дугаар сарын 18-наас 2023 оны 08 дугаар сарын 23-ны хооронд зохион байгуулсан “Мастер Трейнер” сургагч багш бэлтгэх хөтөлбөрт үйлчилгээний ахлах ажилтан,	Сургагч багш бэлтгэх хөтөлбөрийн сургалт-үйлчилгээний ажилтан хамрагдлаа.
5	2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хотод Цахим хөгжил харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороо, Кибер аюулгүй байдлын зөвлөл хамтран зохион байгуулсан 2 өдрийн “Кибер тусгаар тогтнол” форумд Хөвсгөл аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйлчилгээний ажилтан,	Төрийн үйлчилгээний операторын системийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Систем нэгтгэлийн хэлтсээс зохион байгуулдаг 14 хоногийн форум-нийт албан хаагч нар хамрагддаг.


Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтын хүрээнд төрийн албан хаагчдад тасралтгүй сургалт орж цахим үйлчилгээтэй холбоотой үр чадварыг эзэмшүүлж ажилласан байна.

2.1.4 Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангахад анхаарахгүй байна.

Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчдын хүйсийн харьцааг Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулиар тодорхойлон зохицуулсан байна.

Төрийн албаны зөвлөлөөс Хөвсгөл аймгийн нийт төрийн албан хаагчдын хүйсийн харьцааны талаар гаргасан тоон судалгааг графикаар харуулбал дараах байдалтай байна.

График № 2/



Графикаас харахад аймгийн төрийн албанд эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс 2.3 дахин их буюу 70:30 гэсэн харьцаатай байгаа нь аймгийн нийт төрийн албан хаагчдын дунд Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн 10 дугаар 10.3¹⁰ дахь заалтад заасан нийт

¹⁰ Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна

төрийн албан хаагчдын хүйсийн харьцаа 60:40 байх тэнцвэрт байдал Хөвсгөл аймгийн хувьд алдагдсан байна.

Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн бодлогод заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг Хөвсгөл аймгийн улс төрийн болон аймаг, сумдын ЗДТГ-ын удирдах албан тушаалтны хүйсийн харьцааг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №9

Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль		Эрэгтэй албан хаагчийн тоо	Эмэгтэй албан хаагчийн тоо	Харьцаа
Хуулийн заалт	Жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлогын шаардлага			
10.1.1	Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл аймагт 15 хувиас доошгүй байх;	3	0	100 : 0
10.1.1	Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл суманд 25 хувиас доошгүй байх;	43	5	90 : 10
10.1.1	Томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл хороонд 30 хувиас доошгүй байх;	117	14	89 : 11
10.1.2.	Төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх;	57	39	59 : 41
Нийт		220	58	

Хүснэгтээс харахад Хөвсгөл аймгийн төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл аймагт 15 хувиас доошгүй, суманд 25 хувиас доошгүй, баг хороонд 30 хувиас доошгүй байх шаардлагуудыг хангаагүй байна.

Нийт төрийн албан хаагчдын тоон үзүүлэлт болон хуульд заасан бодлогын шаардлагыг хангаагүй байдлаас үндэслэн Хөвсгөл аймгийн төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллаагүй байна гэж дүгнэлээ.

2.2 Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай цахим системийг хөгжүүлж, шат дамжлагыг цөөлөн, иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах боломж бүрдсэн байна.

2.2.1 Төрийн үйлчилгээний чиглэлээр хөгжүүлсэн цахим системийг нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх шат дамжлагыг тодорхой хэмжээнд бууруулсан байна

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 499 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн - Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байгуулагдсан байна.

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар нь Төрийн цахим үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, иргэдэд хүртээмжтэй хүргэн “Иргэн төвтэй нийгэм” байгуулахад шаардлагатай цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино гэсэн алсын харааг баримтлан, дэвшилтэт технологи, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх замаар “Цахим - Үндэстэн” болох ажлыг дэмжин Төрийн цахим шилжилтийг хэрэгжүүлэх ерөнхий зорилго тавин ажиллаж байна.

Аудитаар Хөвсгөл аймгийн Цагааннуур, Ренчинлхүмбэ, Улаан-Уул сумдад ажиллахад Ренчинлхүмбэ сумын ЗДТГ нь төрийн бүх үйлчилгээг цахимд шилжүүлж, 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар КИОСК машин худалдан авч, төрийн 168 төрлийн үйлчилгээг тухайн чиглэлийн мэргэжилтэн байгаа эсэхээс үл хамааран иргэд өөрсдөө авахаар зохицуулсан байна. Иргэдийг КИОСК машин ашиглаж сургах зорилгоор 2 жилийн турш хөтөч ажилтан ажиллуулсан сайн туршлагатай байна.

Аудитын хүрээнд авч буй судалгааны үр дүнгээс харахад дараах байгууллагуудын цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо өндөр үзүүлэлттэй байгааг 2023 оны жилийн эцсийн байдлаар түүвэрлэн харуулбал:

Хүснэгт № 10

№	Байгууллагын нэр	Цахим систем	Байгууллагын үзүүлж буй үйлчилгээний тоо	Цахимаар үзүүлж буй үйлчилгээний тоо
1	Улсын бүртгэлийн хэлтэс	E-mongolia.mn E-Business Киоск		120 66 2
2	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	Ehalmj.mn Ejob.mn	93	18 57
3	БОАЖГ		10	2
4	СТандарт хэмжил зүйн хэлтэс		6	1
5	Мал эмнэлгийн газар		11	6
6	Нийгмийн даатгалын газар	Portal.ndaatgal.mn		Тайлан гаргах, лавлагаа, тодорхойлолт авах үйлчилгээ цахимд шилжсэн
7	Татвар	Mta.mn, E-tax, E-barimt, E-balance		Татвартай холбоотой бүх төрлийн үйлчилгээ цахимд шилжсэн, ашиглаж хэвшсэн
8	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	Egazar.gov.mn	86	56
9	Нэгдсэн эмнэлэг	1800-0119, 75751133 E-mongolia app		Эмнэлэгт үзүүлэх цаг авах үйлчилгээг цахимд шилжүүлж, иргэд ашиглаж хэвшсэн байна.

Иргэд E-mongolia.mn цахим системээс шаардлагатай 188 төрлийн төрийн үйлчилгээг авч хэвшсэн, бусад төрийн үйлчилгээний системтэй интеграци¹¹ хийж, шат дамжлагыг цөөлсөн сайн үр дүнтэй байна.

Ehalmj.mn цахим системээр 2020 оноос хойш халамжийн чиглэлээрх бүх төрийн үйлчилгээг хэрэгжүүлж хэвшсэн байна. Egazar.gov.mn цахим системээр иргэд хүсэлт илгээж, газартай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлүүлж байгаа боловч шийдвэрлэлтэд хяналт тавих боломжоор хангагдаагүй байна.

Татвар болон нийгмийн даатгалын цахим системийг ашиглан тайлан мэдээ илгээх, лавлагаа, тодорхойлолт авч хэвшсэн байна.

Нэгдсэн эмнэлэгт үзүүлэхээр цахим систем болон утсаар цаг авч үйлчлүүлж буй иргэдийн тоо өндөр байгаа ч бодит байдал дээр цаг авсан иргэд үйлчилгээ авахаар очиход авсан цагийн дарааллаар биш очсон дарааллаар дугаарлан үзүүлэх шаардлага үүсдэг. Энэ нь цаг авах үйлчилгээ нь өөрөө тухайн эмч хэдэн иргэнд үйлчилсэн талаарх бүртгэл төдий хэлбэртэй байна.


Аймаг, сумдын ЗДТГ-ууд нь төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, шат дамжлага, хүнд суртлыг цөөлөх зорилгоор КИОСК машин байршуулж, ХҮР-DAN үйлчлэх төвийг ажиллуулж, иргэд үйлчлүүлж хэвшсэн, хэлтэс, агентлагууд нь тус бүртээ өөрсдийн үзүүлж буй үйлчилгээний чиглэлээр хөгжүүлсэн цахим системийг нэвтрүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж, шат дамжлагыг тодорхой хэмжээнд бууруулсан байна.

2.2.2 “ХҮР” систем ашиглан иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран жигд хүртээмжтэй авч хэвшсэн байна.

Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, ил тод, үр ашигтай хүргэх шийдлүүдийн тэргүүнд Нэг цэгийн үйлчилгээ орох юм. 2007 онд эхлэл нь тавигдаж, 2013 оноос улс орон даяар нэвтэрсэн Нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр аймаг, сумын төвшинд нийгмийн

¹¹ Нэгдэх, холбогдох, бүсчлэх

хамгааллын болон хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө өгөх үйлчилгээ, мөн нотариат болон банкны үйлчилгээг үзүүлж байсан.



Монгол улсын Засгийн газрын 2016 оны 141 дугаар тогтоолоор “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-өөр дамжуулан иргэн хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээний журмыг баталсан бол, 2019 онд Монгол улсын засгийн газрын 149 дүгээр тогтоолоор “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйлчилгээг дуудлагын буюу операторт шилжүүлж, “Үйлчилгээний нэгдсэн төв” болгон зохион байгуулах, бүх сумдад “Үйлчилгээний нэгдсэн төв” байгуулж төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхийг аймаг нийслэлийн Засаг дарга нарт даалгасан. Ингэснээр төрийн мэдээллийн “ХУР” системийг ашиглан төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, жигд хүртээмжтэй үзүүлэх цаашид цахимаар авах үйлчилгээнүүдийн төрөл, тоо нэмэгдэх үндэс суурь болж өгсөн байна.

“ХУРДАН” төв нь иргэдэд төрийн 39 байгууллагын нийт 440 үйлчилгээг нэг цонхноос авах түргэн шуурхай, зардал чирэгдэлгүй хүргэх систем юм. Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх шат дамжлагыг цөөлөн, ийнхүү цахим хэлбэрт шилжсэнээр гар утаснаасаа, киоск машинаас, эсвэл өөрт хамгийн ойр байрлах Хурдан төвөөс хүссэн хэдэн ч төрлийн үйлчилгээг 10-15 минутын дотор нэг цонхноос авах боломж бүрдэж байгаа юм.

Аймгийн төв болон сумдад байгаагаас үл хамааран “ХУР” систем ашиглан иргэд төрийн үйлчилгээг авч хэвшсэн байна

2.3 Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдалд үнэлгээ өгөхөд иргэд олон нийтийн оролцоо хангалтгүй байна.

2.3.2 Цахим системээр иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан хэдий ч иргэдийн хамрагдалтын хувь бага байгаа нь бодит үнэлгээ болж чадахгүй байна.

Хөвсгөл аймгийн ЗДТГ, Төрийн албаны салбар зөвлөлөөс 2013 оноос 2023 онд 1 удаа буюу 2017 онд сумдын ЗДТГ-н төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд сэтгэл ханамжийн судалгааг хийсэн байна. Судалгааны дүнгээр нийт сумдын ЗДТГ-ын үйлчилгээний ил тод байдалд судалгаанд оролцсон иргэд ерөнхийдөө хангалтгүй гэсэн үнэлгээг өгсөн байна. Судалгааны үр дүнд аймаг, орон нутгийн үйл ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэх, хэвлэл мэдээллийн тусгай сувгуудыг бий болгох /сонин, тв, радио гэх мэт/ нэг зөвлөмжийг өгсөн байна.

Аудитаар түүвэрлэн шалгасан байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хянан үзэхэд Рэнчинлхүмбэ сумын ЗДТГ нь орон тооны бус 5 хүний бүрэлдэхүүнтэй хэвлэл мэдээллийн баг томилон ажиллуулдаг, 2024 оны 7 дугаар сард Ай-Ти солюшн ХХК-тай гэрээ байгуулан байгууллагын вэб сайт хөгжүүлэн ажиллаж байна. Хөгжүүлэлтийн хувь 40%, Цагааннуур сумын ЗДТГ нь өөрийн байгууллагын вэб хуудас хөгжүүлэлтийн зардалд 1.5 сая төгрөг зарцуулж, хөгжүүлэлтийн шатандаа явж байна.


Хэлтэс, агентлагууд өөрсдийн гэсэн цахим хуудсыг тогтмол ажиллуулж, тухайн цахим хуудсаар дамжуулан иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа, байгууллагын үйл ажиллагаа, үзүүлсэн үйлчилгээний талаар мэдээллийг тогтмол мэдээлж хэвшсэн байна.

Цахим системээр иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан хэдий ч иргэдийн хамрагдалтын хувь бага байгаа нь бодит үнэлгээ болж чадахгүй байна.

2.3.3 Сүүлийн 8 жилд Хөвсгөл аймгийн шударга байдлын үнэлгээ буурч 8 байраар ухарсан байгаа нь төрийн албанд авлигын эрсдэл тодорхой хэмжээгээр өссөн байх магадлалтайг харуулж байна.

Берлинд төвтэй “Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагын гаргадаг авлигын төсөөллийн индексээр Монгол улс 2023 оны жилийн эцсийн байдлаар дэлхийн 180 орноос 33 оноотой 121 дүгээр байр эзэлж өмнөх онтой харьцуулбал 5 орноор байр ухарсан үзүүлэлттэй байна. “Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагын сүүлийн 11 жилийн онооны үзүүлэлтээр авлигын индексийн өсөлт бууралтыг харуулсан графикаас харахад Монгол улс 39 оноотой 80 дугаар байр эзэлсэн 2014 оноос хойш тогтмол оноо буурч ухарсан үзүүлэлттэй байна.

/График № 3/



Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.7¹²-д заасны дагуу шударга байдлын үнэлгээг 2015 оноос 7 удаа хийсэн байна. Шударга байдлын үнэлгээгээр аймгуудыг үнэлэхдээ аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаагаар тогтоон үнэлж байгаа бөгөөд сүүлийн 8 жилд Хөвсгөл аймаг хэддүгээр байр эзэлж байсныг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт № 11

Он	2015	2016	2018	2019	2021	2022	2023
Шударга байдлын үнэлгээний аймгийн оноо	79	68.6	64.7	71.8	59	64.3	76.6
Шударга байдлын үнэлгээний улсын дундаж	73.8	69.7	68.7	74.1	72.9	73.9	72.9
Эзэлсэн байр /аймаг, нийслэлийн ЗДТГ-аас/	3	10	14	14	22	19	11

Хүснэгтээс харахад Хөвсгөл аймаг шударга байдлын үнэлгээгээр 2015-2023 онд 8 байраар ухарсан байгаа нь төрийн албанд авлигын эрсдэл тодорхой хэмжээгээр өссөн байх магадлалтайг харуулж байна.

Аудитаар нийт 152.4 сая төгрөгийн 15 зөрчил илрүүлж, 152.4 сая төгрөгийн 18 зөвлөмж, 3 албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газарт 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор гаргаж ирүүлнэ үү.

¹² төрийн үйлчилгээ авсан иргэд, байгууллагын судалгаанд тулгуурлан төрийн байгууллагын шударга байдлын түвшинд 2 жил тутамд үнэлгээ гаргаж, олон нийтэд мэдээлэх.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Төрийн байгууллагын хүний нөөцийн асуудлыг зохицуулж буй хууль эрх зүйн орчин хангалттай хэдий ч төрийн албаны хүний нөөцийн чиглэлээр баримтлах стратеги төлөвлөгөө боловсруулан батлаагүй, төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг бодит байдал нийцүүлэн хийдэггүй зэрэг нь хуулийн тодорхой зохицуулалтуудыг хангахгүй байгааг харуулж байна.
2. Төрийн үйлчилгээний байгууллагуудад нөөцийн хуваарилалтыг оновчтой хийгээгүйгээс боловсрол, эрүүл мэндийн салбар боловсон хүчний дутагдалд орж төрийн үйлчилгээний үр дүнг бууруулж байна.
3. Эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийдэггүй, улс төрийн нөлөөнөөс ангид, тогтвортой ажиллуулах нийгмийн баталгаагаар төрийн албан хаагчийг хангаагүй, төрийн албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлээгүй байгаагаас үзэхэд хүний нөөцийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлж чадахгүй байгааг харуулж байна.
4. Төрийн үйлчилгээний албаны сул орон тоог нөхөх үйл явцыг хууль, журмаар тодорхойлж өгөөгүйгээс нөхөгдөх үйл явц удаашралтай, аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн хяналт сул, албан хаагчийг сэлгэн болон шилжүүлэн ажиллуулахдаа холбогдох хуульд заасан шаардлагыг хангаагүй албан хаагчийг томилсон байгаа нь төрийн албыг мэдлэг чадвартай, туршлагатай албан хаагчаар гүйцэтгүүлэхэд сөрөг нөлөө үзүүлэх, төрд итгэх итгэл үнэмшлийг бууруулж байна.
5. “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим систем нь төрийн байгууллагад гарсан сул орон тоо, нөөцөд бүртгэлтэй иргэдийн жагсаалт, сэлгэн, шилжүүлэн ажиллуулсан мэдээлэл, гүйцэтгэлийн үнэлгээ, шагнал урамшуулал, нийгмийн баталгаа зэрэг төрийн байгууллагын хүний нөөцтэй холбоотой чухал шаардлагатай тайлан мэдээг боловсруулах системийн хөгжүүлэлт хийгдээгүй нь хяналтыг цахимаар хэрэгжүүлэх, алдаа зөрчлийг бууруулах, төрийн байгууллагын хүний нөөцөд шаардлагатай дүн шинжилгээ хийх тоон мэдээ бэлтгэх, зөвлөн сайжруулах боломжийг хязгаарласан, зөвхөн цалин бодоход зориулж мэдээлэл бүрдүүлдэг хэлбэртэй байна.
6. Төрийн үйлчилгээг цахимжуулахад шаардлагатай хүний нөөцийг сургаж, чадавхжуулан, иргэдэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран цахим системээр үзүүлэх боломжтой байгаа нь ил тод төрийн алба төлөвших нөхцөл бүрдсэнийг харуулж байна.
7. Төрийн албанд эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс 2.3 дахин их буюу 70:30 гэсэн харьцаатай байгаа нь Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангахад анхаарахгүй байгааг харуулж байна.
8. Сүүлийн 8 жилд Хөвсгөл аймгийн шударга байдлын үнэлгээ буурч 8 байраар ухарсан байгаа нь төрийн албанд авлигын эрсдэл тодорхой хэмжээгээр өссөн байх магадлалтайг харуулж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Цэнд-Аюушд:

1. Сул орон тооны мэдээллийг тухай бүр нийтэд ил тод мэдээлж байх
2. Сул орон тооны захиалгыг хуульд заасан хугацаанд Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, хуульд нийцүүлэн нөхөн томилгоо хийж ажиллах

Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Төмөрбаатарт:

3. Харьяа байгууллагуудын хүний нөөцийн чиглэлээр хэрэгжүүлж ажиллах дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан, баталж, хэрэгжилтийг хангаж ажиллах
4. Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулж ажиллах
5. Төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллах
6. Хөвсгөл аймгийн шударга байдлын үнэлгээг ахиулах арга хэмжээ авч ажиллах

Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын дарга Г.Гандэлгэрт:

7. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, бодитой үнэлж хэвших
8. Сул орон тооны мэдээллийг тухай бүр нийтэд ил тод мэдээлж байх
9. Сул орон тооны захиалгыг хуульд заасан хугацаанд Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, хуульд нийцүүлэн нөхөн томилгоо хийж ажиллах
10. Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг хууль, журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулах

Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн дарга Л.Юмжирдуламд:

11. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийж, хэрэгжилтийг хангуулж ажиллах талаар харьяалах байгууллагуудад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх
12. Хууль бус томилгоотой албан тушаалтанд өгсөн Төрийн албаны зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллах
13. Төрийн албан хаагчийн буруутай шийдвэрийн улмаас төрд учирсан хохирлыг шүүхэд нэхэмжлэл гаргах, энэ талаарх саналыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх,
14. Сул орон тооны мэдээллийг нийтэд ил тод мэдээлээгүй, захиалга ирүүлэх хугацаа хоцроосон, захиалга ирүүлээгүй нуун дарагдуулсан, хууль бус томилгоо хийсэн буруутай албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан хариуцлагын арга хэмжээг тооцох саналыг хүргүүлэх

Аймгийн Боловсролын газрын дарга, Эрүүл мэндийн газрын дарга нарт:

15. Боловсрол, эрүүл мэндийн албарын байгууллагуудад гарч байгаа сул орон тоог шаардлагад нийцсэн албан хаагчаар нөхөж, нөөцийн хуваарилалтыг оновчтой хийж ажиллах

Сумдын ЗДТГ, хэлтэс, агентлаг, байгууллагын дарга нарт:

16. Хүний нөөцийн чиглэлээр баримтлах бодлогын баримт бичгийг Монгол Улсын дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн боловсруулж, жил бүр хэрэгжилтийг тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж хэвших
17. Хүний нөөцийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцож, хяналт, шинжилгээ үнэлгээ хийж хэвших
18. Байгууллагад гарсан сул орон тооны мэдээллийг тухай бүр Төрийн албаны тухай хуульд заасан хугацаанд ил тод нийтэд мэдээлж, төрийн албаны салбар зөвлөлд захиалгыг хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

Зөрчлийн жагсаалт:

№	Илэрсэн зөрчлийн	Дүн	Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Засаг дарга нь төрийн албаны хүний нөөцийн чиглэлээр стратеги төлөвлөгөө батлаагүй байна.	-					1	-
2	Сул орон тооны захиалгыг хуульд заасан хугацаанд Хөвсгөл аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээгүй, хуульд нийцүүлэн нөхөн томилгоо хийгээгүй.	-			3	-	3	-
3	Эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ аваагүй байна.	-					1	-
4	Нийт төрийн албан хаагчдын тоон үзүүлэлт болон хуульд заасан бодлогын шаардлагыг хангаагүй байдлаас үндэслэн Хөвсгөл аймгийн төрийн албанд жендерийн тэнцвэртэй байдлыг хангаж ажиллаагүй байна.	-					1	-
5	Хөвсгөл аймгийн шударга байдлын үнэлгээ 2015-2023 онд 8 байраар ухарсан байна.	-					1	-
6	Төрийн байгууллагын хүний нөөцийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг бодитоор тооцож, үнэлгээгүй байна.						1	-
7	Сул орон тооны мэдээллийг тухай бүр нийтэд ил тод мэдээлж байх						2	-
8	Аймгийн Засаг даргын чиг үүргийн шинжилгээ хийх ажлын хэсгийн дүгнэлтгүйгээр Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 334, 335 дугаар тогтоолуудаар АИТХ-ын ажлын албаны болон аймгийн ЗДТГ-ын газар хэлтсийн дарга нарын болон зарим албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтын дахин шинэчилж баталсан байна						1	-
9	Төрийн байгууллагад сул орон тоо гарсан тохиолдолд хуульд заасан хугацаанд нийтэд мэдээлээгүй, Төрийн албаны салбар зөвлөлд 21 хоногийн дотор захиалгыг ирүүлэхгүй хоцроож ирүүлсэн, сул орон тоог зарлуулаагүй удаан хугацаанд сул хэвээр хадгалсан тохиолдол бүрд салбар зөвлөл нь шаардлага тавьж, Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.						1	-
10	Хөвсгөл аймгийн Засаг дарга нь Байгаль, орчин аялал жуулчлалын газрын дарга П.Мөнхжаргалыг Архангай аймгийн Хайрхан сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд шалгалт өгч тэнцээд удаагүй байхад Хөвсгөл аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын даргаар шилжүүлэн томилсон байна. Тухайн томилгоонд Төрийн албаны зөвлөлөөс хяналт хэрэгжүүлж, зөрчилтэй болохыг тогтоож, үүрэг өгсөн боловч тогтоолын хэрэгжилтийг хангаагүй байна.						1	-
11	Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.3-т заасан үүргийн хүрээнд Хөвсгөл аймгийн санхүүгийн хяналт аудитын алба, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Төлбөрийн актын дагуу буцаан төлөгдсөн 14.8 сая төгрөг, авлагаар тусгуулсан 56.1 сая төгрөг байгаа боловч 152.4 сая төгрөгийн хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.	152.4					1	152.4
12	Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт хэрэгжихгүй байгаа нь төрийн байгууллагын хүний нөөцийн мэдээллийн ил тод байдал алдагдсан, хариуцлагын арга хэмжээ						1	-

	хэрэгжихгүй байгаагаас тухайн зөрчил давтан гарсаар байна.							
13	Сургуулийн өмнөх боловсролын 1 багшид анги дүүргэлт 45-55 хүүхэд байгаа нь ажлын ачаалал, боловсролын үйлчилгээний хүртээмж, нөөцийн хуваарилалт хангалгүй байгааг илтгэж байна.						1	-
14	Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул сумдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан төрийн байгууллагын хүний нөөцийн чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг өөрсдөө үнэлж, аймгийн ЗДТГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст нэгтгүүлдэг байна.						1	
15	Төрийн захиргааны байгууллагын хувьд орон нутаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн хяналт хэрэгждэг учраас сул орон тоо харьцангуй бага байгаа ч 3-5 жил нөхөгдөөгүй албан тушаалын хувьд хүний нөөцийн чадавх сул, орон нутагт сэлгэн, шилжүүлэн ажиллахад нийгмийн баталгаа, амьдрах орчин нөхцөлөөр хангагдахгүй, тухайн чиглэлээр шинээр боловсон хүчин бэлтгэгдэхгүй, энэ талаар аймаг орон нутгийн эрх бүхий байгууллагууд бодлогын түвшинд асуудлыг шийдэж ажиллаагүйтэй холбоотой байна.						1	
НИЙТ ДҮН		152.4			3		18	152.4

ажиллагааны зардалтай, нэгж болгож, нэг албан хаагчид ногдох ажлын ачааллыг бодитой, үндэслэлтэй тогтоож, тэнцвэртэй хуваарилаагүй нөхцөлд хуулийн бүрэн хэрэгжилт хангах, хяналт бүрэн тогтоох боломжгүй юм.

3. Салбар зөвлөлийн ажиллах нөхцөл огт хангагдаагүй. Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Төрийн албаны зөвлөлөөс томилгоотой боловч аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцэд ажиллаж, аймгийн Засаг даргын Тамгын газраас ажлын өрөө, бичиг хэргийн зардал, нарийн бичгийн даргын цалин хөлсийг шийдвэрлэж ажиллаж байна. Салбар зөвлөл хуулийн хүрээнд дээрх олон чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд тодорхой төсөв шаардагдах боловч 2021-2024 онд үйл ажиллагааны төсөвгүй ажилласан. Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулахад байр танхим, ширээ сандал, цахим шалгалтад ашиглах тоног төхөөрөмж, компьютер шаардлагатай ба энэ үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмж, танхим, ширээ сандалгүй, жилдээ 15-20 удаагийн давтамжтай зохион байгуулж буй шалгалтыг төрийн байгууллагуудаас гуйж, тухай бүрд олох, тухай бүрд танхим тохижуулах байдлаар ажиллаж байна.

4. Салбар зөвлөл бие даасан, хараат бусаар ажиллах нөхцөл хангагдаагүйн улмаас Салбар зөвлөлийн даргыг улс төрийн албан хаагч чөлөөлөх, удаа дараалан даргын үүрэг гүйцэтгэгч ажиллах, салбар зөвлөлийн гишүүдийн үндсэн томилгоог улс төрийн албан хаагч хийдэг байдлаас шалтгаалж тухайн дарга, гишүүдийг дарамтлах, хууль бус үйл ажиллагаа явуулахыг шаардах, ажлаас чөлөөлөгдөх эрсдэлүүд бодитой үүссэн.

Иймд тайланд Салбар зөвлөлийн бүтцийг бие даасан, ажлын ачаалал, чиг үүргийн хувьд бусад төрийн албан хаагчдын ижил түвшинд, ажиллах нөхцөл бүрэн хангагдсан байхаар тогтоолгох, Төрийн албаны зөвлөлд хэт төвлөрсөн чиг үүргийн (маргаан хянан шалгах, төрд учирсан хохирол нэхэмжлэх, хүний нөөцийн аудит, албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрөл олгох) эрх, үүргийг Салбар зөвлөлд тодорхой хэмжээгээр шилжүүлэх саналыг хүргүүлж байна.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЮМЖИРДУЛАМ

Аудитаар өгсөн албан шаардлагууд:



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 10 сарын 10 өдөр № 94/А2270469/ Мөрөн сум
ХӨА-2024/19-21-ШТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Засаг даргын тамгын газрын хүний нөөцийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Засаг даргын тамгын газрын дарга, бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоог хууль, журмын дагуу захиалга өгч, сонгон шалгаруулалт зарлуулаагүй байна.

Дээрх зөрчил нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.11-т “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн албаны сул орон тоог холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн томилохгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор нотлох баримтын хамт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг Цагааннуур сумын засаг дарга Б.Цэрэн-Очирт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	А.ЭРДЭНЭБААТАР
АУДИТОР	Г.ИЧИНХОРЛОО
АУДИТОР	Б.АРИУНТУЯА



¹ Монгол Улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр

6724020956



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 11 сарын 20 өдөр

№ 99/АБЭТӨНӨС/ХӨА -2024/

Мөрөн сум

19-21 - ШТА - ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" гүйцэтгэлийн аудитаар Хөвсгөл аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын хүний нөөцийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд шалгуур хангаагүй албан хаагч томилон ажиллуулж байна.

Дээрх зөрчил нь Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно.", 26 дугаар зүйлийн 26.1-т "Төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилно." гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.11-т "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

3. Төрийн албаны сул орон тоог холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн томилогүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор нотлох баримтын хамт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх;
4. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг Хөвсгөл аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын дарга Т.Раднаабүд, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Алтанцоож нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Г.ИЧИНХОРЛОО



¹ Монгол Улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 302 тоот



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 11 сарын 20 өдөр

№ 100/A2270469/ХӨА-2024/
19-21-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" гүйцэтгэлийн аудитаар Хөвсгөл аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын хүний нөөцийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Нягтлан бодогчийн ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаагүй, шууд томилгоо хийсэн байна.

Дээрх зөрчил нь Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 3.2-т "Эрх бүхий албан тушаалтан нь төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийг нээлттэй сонгон шалгаруулж, саналаа дараах материалын хамт энэ журмын 3.1-д зааснаар зөвшилцөх албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.11-т "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төрийн албаны сул орон тоог холбогдох хууль тогтоомжийн дагуу нөхөн томилохгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дотор нотлох баримтын хамт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг Хөвсгөл аймгийн Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын дарга Т.Раднаабүд, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Алтанцоож нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Г.ИЧИНХОРЛОО



¹ Монгол Улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3-дугаар 302 тоот

67240.0368

